

Иргэдэд зориулсан гарын авлага

МЭДЭХ ЭРХ

Эмхэтгэн боловсруулсан:

Б.Батзориг

/Хууль зүйн ухааны доктор/

Х.Наранцэцэг

Зургийг:

Д.Гансүх

Энэ гарын авлагыг “Глоб интернэшил төв” ТББ-аас эрхлэн гаргасан материалуудад тулгуурлан хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын хуулийн хүрээнд боловсруулав.

ГАРЧИГ

ИРГЭНИЙ МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ.....	5
Мэдээлэл олж авах эрх, эрх чөлөөний ойлголт	5
Надад яагаад мэдээлэл хэрэгтэй вэ?	6
Мэдэх эрх гэж юу вэ?	10
Би ямар хэлбэрээр мэдээлэл олж авч болох вэ?	11
Мэдээлэл надад ямар ач холбогдолтой вэ?	11
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГААС МЭДЭЭЛЭЛ ОЛЖ АВАХ ИРГЭНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ....	12
Төр, засаг мэдээллээ ил тод болгох үүрэг хүлээдэг үү?	12
Төрийн байгууллагад ямар мэдээлэл хадгалагддаг вэ?	13
Мэдээлэл сайтай иргэд төрд ямар ач тустай вэ?	13
Төрийн байгууллагаас иргэдэд зориулан түгээж буй мэдээлэл ямар байх ёстой вэ?	13
Иргэд төрийн байгууллагын үйл ажиллагааны талаар мэдээллийг ямар аргаар олж авч байна вэ?	14
Ямар мэдээллийг төрийн байгууллагаас авахыг хориглодог вэ?	14
Ямар мэдээллийг төрийн нууцад хамааруулдаг вэ?	14
Байгууллагын нууцыг хэрхэн тогтоодог вэ?	15
Байгууллага ямар мэдээллийг нууцалж болохгүй вэ?	15
Хувь хүний нууц гэж юу вэ?	16
"МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ" ХУУЛЬ	17
"Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай" хууль төрийн ямар байгууллагуудад хамаарах вэ?	17
Төрийн байгууллагуудад ямар мэдээллийг ил тод байлгах үүрэг ногдуулсан бэ?....	18
Төрийн байгууллагууд дээрх мэдээллүүдийг олон нийтэд хэрхэн нээлттэй, ил тод болгох вэ?	18
Би төрийн байгууллагаас ямар мэдээлэл авах эрхтэй вэ?	18
Би мэдээлэл авах тухай хүсэлтээ хэрхэн гаргах вэ?.....	18
Мэдээлэл хүсэж буй иргэн ямар эрхтэй вэ?	19
Би мэдээлэл авах хүсэлт гаргахдаа шалтгаанаа тайлбарлах ёстой юв?	20
Миний хүсэлтийг ямар тохиолдолд буцаах вэ?	20
Би хүссэн мэдээллээ ямар хэлбэрээр авч болох вэ?	20
Миний мэдээлэл авах хүсэлтэнд ямар хугацаанд хариу өгөх вэ?.....	20

Би мэдээлэл авсныхаа төлөө төлбөр төлөх үү?	21
Надад мэдээлэл өгөхөөс татгалзсан төрийн албан хаагчийн талаар гомдол гаргаж болох үү?	21
Надад мэдээлэл өгөөгүй байгууллага, албан тушаалтанд ямар хариуцлага хүлээлгэх вэ?	21
Төрийн байгууллагуудад ямар мэдээллийг олон нийтэд нээлттэй ил тод байлгахыг хориглосон бэ?	22
ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГТЭЙ ТАНИЛЦАХ ЭРХ	23
Би албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлэгтэй танилцах эрхтэй юу?	23
Албан тушаалтан хөрөнгө, орлогын мэдүүлгээ хэдийд гаргаж өгөх үүрэгтэй вэ?	23
Би албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй танилцах хүсэлтээ хаана, хэнд гаргах вэ?	23
Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг ямар байдлаар олон нийтэд мэдээлдэг вэ?	24
Нийтийн албан тушаалтан ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ мэдэгдэх үүрэгтэй юу?	24
Ямар албан тушаалтнууд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах вэ?	25
Би албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэгтэй танилцах эрхтэй юу?	25
Би албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэгтэй танилцахыг хүсвэл хаана, хэнд хандах вэ?	25
Хувийн ашиг сонирхлын мэдүүлэгтэй холбоотой гомдол, мэдээллийг ямар байгууллага шалгах вэ?	26
МЭДЭЭЛЭЛ ОЛЖ АВАХ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ ЗӨРЧИГДСӨН ГЭЖ ҮЗВЭЛ ГОМДОЛ ГАРГАХ ЭРХ	27
Иргэдэд мэдээлэл өгөх үйл ажиллагаатай холбоотойгоор төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргах өргөдөл, гомдол гэж юу вэ?	27
Ямар тохиолдолд өргөдөл, гомдлыг хүлээн авч, хянан үзэхгүй вэ?	27
Өргөдөл, гомдлын талаар төрийн байгууллага, албан тушаалтан ямар нийтлэг үүрэг хүлээх вэ?	27
Гомдол хэрхэн гаргах вэ?	28
Өргөдөл, гомдол гаргагч ямар эрхтэй вэ?	28
Надад мэдээлэл өгөхөөс татгалзвал гомдол гаргаж болох үү?	28
Иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл авах эрхийг зөрчсөн байгууллага, албан тушаалтанд ямар хариуцлага хүлээлгэх вэ?	30
МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬ	31
МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС ТӨЛӨХ, ТҮҮНЭС ХӨНГӨЛӨХ, ЧӨЛӨӨЛӨХ ЖУРАМ	47

ИРГЭНИЙ МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ

ИРГЭН ТА

1. Төлөөлөлтэй байх эрхтэй
2. Үйл ажиллагаа явуулах эрхтэй
3. Мэдэх эрхтэй

Мэдээлэл олж авах эрх, эрх чөлөөний ойлголт

*“Мэдээллийн эрх чөлөө нь хүний язгуур эрх бөгөөд...
НҮБ-аас тунхагласан бусад эрх, эрх чөлөөг хэмжих үндсэн
хэмжүүр мөн”*

*НҮБ-ын Ерөнхий Ассамблейн анхдугаар
чуулга уулзалтнын 59-р тогтоол /1948 он/*

Хуучин дэглэмийн үед буюу 1990 оноос өмнө төр нь иргэдийг үг дуугүй захирч, өөртөө үйлчлүүлдэг нийгэмд бид амьдарч байлаа. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл угтаа зөвхөн нэг намд үйлчилж байв. Ийм нийгэм цөөн тооны хүнээс бүрдсэн удирдах бүлэгт шүтэж, ард түмэн зөвхөн тэдний захиргаадалтын дор оршин байв. Энэ үед иргэдийн хүссэн, хэрэгцээтэй мэдээллийг бус эрх барьж буй хүмүүсийн (хүний) түгээхийг хүссэн мэдээллийг л олон нийтэд хүргэдэг байв. Ард түмнийг ямар ч мэдлэг, мэдээлэлгүй (хаосон цаас мэт) байлгах нь эрх мэдэлтнүүд юу хүссэнээ хийж дураараа авирлах боломжийг өгч байжээ.



Хүмүүнлэг ардчилсан нийгэм дэх хүний хамгийн чухал эрх, эрх чөлөө бол мэдээллийн эрх, эрх чөлөө юм. Та агааргүй бол амьсгалж чадахгүйтэй адил хүний нийгэмд мэдээлэлгүй бол амьдарч чадахгүй. Хүнийг иргэний нийгмийн “амьтан” биш “хүн” шиг байлгахад тусалдаг хамгийн хүчтэй зүйл бол мэдээлэл.

Хүний анхдагч хэрэгцээг хоол хүнс, хувцас, орон сууц гэж тодорхойлдог. Гэвч бид хоол хүнсээ хаанаас олж авах, орон сууцаа хэрхэн барихад **мэдээлэл хэрэгтэй болдог**. Тийм ч учраас хүн мөнгөө хоол хүнс, хувцас, орон сууцандaa зарцуулахаас гадна мэдээлэл олж авахад ашигладаг. **МЭДЭЭЛЭЛТЭЙ ИРГЭД ХҮЧИРХЭГ БАЙДАГ**.

Мэдээллийн эрх, эрх чөлөөнд:

- Хүн мэдээлэл хүртэх;
- Мэдээлэл олж авах;
- Мэдээлэл түгээх эрхүүд тус тус багтдаг.

Хүн дээр дурьдсан эрхгүйгээр өдөр тутмын ажил төрлөө зохицуулах, орчин

нөхцөлдөө зөв үнэлэмж өгөх, нийгмийн амьдралд зохих ёсоор идэвхитэй оролцох ба нийгмийн гишүүнийхээ үнэ цэнийг мэдэрч амьдрах ямар ч боломжгүй байдаг болохоор тухайн эрх нь хүний үндсэн эрхүүдийн тоонд зүй ёсоор багтдаг.

Надад яагаад мэдээлэл хэрэгтэй вэ?

ЯАГААД ГЭВЭЛ ТА ТӨР НЬ ИРГЭНДЭЭ ҮЙЛЧИЛДЭГ АРДЧИЛСАН НИЙГЭМД АМЬДАРЧ БАЙНА. Энэ нийгэмд

ТА ТӨРИЙН ЭЗЭН

ТА ТӨРӨӨ СОНГОДОГ

ТА ТӨРӨӨ САНХҮҮЖҮҮЛДЭГ.

Мэдээлгүй иргэн өөрийн бодож, төсөөлснөөр асуудалд хандаж байгааг буруутгах аргагүй. Иргэд үнэн, бодит мэдээллээр хангагдсанаар асуудалд бодитой ханддаг болно. Өөрөөр хэлбэл зөв үнэлэлт, дүгнэлт өгөх боломж нээгдэн төрийн байгууллагын үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт тавих боломжтой болно.

Улс орноо удирдахад танд мэдээлэл хэрэгтэй. Тогтмол хугацаанд болдог, чөлөөтэй, шударга сонгууль бол таны улс орныхоо ирээдүйг шийдвэрлэх үйл хэрэгт биечлэн оролцох боломж юм. Улс төрийн сонгууль аль хэр шударга болох нь таны аль хэр мэдээлэлтэй байхаас шалтгаална. Та сонгуулийн ухуулга сурталчилгаа, хэвлэл мэдээллийн мэдээлэл, сурвалжлага, улс төрийн нам, нэр дэвшигчдийн уулзалт, мэтгэлцээний явцад олж авсан мэдээлэлдээ үндэслэн сонголтоо хийнэ. **Танд гагцхүү үнэн, бодитой, тэнцвэртэй мэдээлэл хэрэгтэй.**

Нийгэмд хүн бүр адилхан эрх мэдэлтэй байх боломж байдаггүй. Тийм учраас та өөрийнхөө итгэж сонгосон хүнд бүрэн эрхийнхээ хугацаанд эрх мэдэл эдэлж, шийдвэр гаргах зөвшөөрөл олгож байгаа юм. Иймд сонгуульт албан тушаалтан хувь хүн, эсвэл хэсэг бүлэг хүмүүс хувийн ашиг сонирхлынхоо төлөө эрх мэдлээ урвуулан, хэтрүүлэн ашиглаж, зүй бус авирлахаас урьдчилан сэргийлж, та **ХЯНАЛТ** тавих үүрэгтэй. **Ингэхийн тулд та мэдээлэлтэй байх ёстой.**

Ард түмний хөрөнгийг хянахын тулд танд мэдээлэл хэрэгтэй. Та улсад хүн амын орлогын, ашиг орлогын, нэмүү өртгийн гэх мэт 10 гаруй төрлийн татвар төлдөг. Энэтатвар нь улсын төсвийг бурдүүлж, төр, засаг, түүний байгууллагуудын үйл ажиллагаанд зарцуулагддаг. Өндөр настай эцэг, эхээ асрах, өвчин эмгэгтэй үр хүүхдээ эмчлүүлэх гээд амьдралын хамгийн чухал шаардлагаар танд мөнгө хэрэгтэй байлаа ч татвар төлөх ёстой. Учир нь төр, засгийн байгууллагууд танд үйлчлэхийн тулд үйл ажиллагаагаа хэвийн явуулах учиртай. Харин та мөнгөө хэн нэгэн албан тушаалтнаар үрэн таран хийлгэхгүйн тулд **ХЯНАЛТ** тавих үүрэгтэй. **Үүний тулд танд мэдээлэл хэрэгтэй.**

Ийм учраас Иргэн Та:

Төрийн үйл хэрэгт шууд оролцох эрхтэй. Төрийн үйл ажиллагаанд хяналт тавих эрхтэй. Энэ бол таны эрх төдийгүй үүрэг юм. Та үүргээ умартаж, хариуцлага алдвал төр самуурч мэднэ.

Шууд оролцоо гэж юу вэ?

Иргэдийн шууд оролцоо гэдэг нь товчхондоо төрийн бодлогод нөлөөлж, хүсч буй шийдвэрээ гаргуулахыг хэлнэ. Та өөрийн санаа бодол, үзэл бодлоо төрөөс баримтлах бодлого, амьдралд нийцтэй шийдвэр гаргахад тусгах бүрэн боломжтой. Өөрөөр хэлбэл, иргэд удирдагчдаа сонгон хүний эрх, ард түмнийхээ сайн сайхан аж байдлын төлөө төр засагтай хамтран ажиллана гэсэн үг юм.

Төрийн бодлого гэдэг нь хүний эрхийг хамгаалж, сайн сайхан амьдралын нөхцлийг хангах төрийн үүрэг хариуцлагын тухай нэгдмэл ойлголт юм.

*Монгол улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна.
Монголын ард түмэн төрийн үйлхэрэгт шууд оролцож, мөн сонгон байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.*

Монгол улсын Үндсэн хууль, 3-р зүйл

Иргэд ардчиллын үйл явцад идэвхтэй оролцохгүй бол эрх баригч, улс төрч, албан тушаалтан, эрх мэдэлтнүүдийг хүссэнээ хийж, дур зоргоороо авирлахыг зөвшөөрсентай адил юм. Тэгвэл төр засгийн удирдлагууд хэмжээлшгүй эрхтэн дархтан болж, иргэдийн эрх, чөлөө хумигдан дарга шүтдэг дарангуйллын тогтолцоо руу эргэн очно гэсэн үг юм.

Иргэдийн оролцоо шууд бөгөөд идэвхтэй бол:

- Эрх мэдлээ урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлнэ;
- Төр засаг, иргэдийнхээ хүсэл зорилгын тухай мэдээлэлтэй байна;
- Олон нийттэй зөвшилцсөний үндсэн дээр зөв, амьдралд нийцэхүйц шийдвэр гарна;
- Төр засаг, түүний байгууллагын үйл ажиллагаа ил тод байж, иргэд илүү мэдээлэлтэй байна;
- Нийгмийн сөрөг үзэгдлүүдтэй тэмцэхэд төр засаг, олон нийт хамтран ажиллана;
- Иргэд хүчирхэгжиж, хүний хөгжил дээшилнэ;
- Нийгмийн сэтгэл зүй зөв төлөвшиж, олон нийт айдас хүйдсээс ангижирна.

Энэ бүхэнд мэдээлэл чухал үүрэг гүйцэтгэнэ. Иргэдийн шууд оролцоог хангахын тулд доорхи гурван эрх, эрх чөлөөг хамгаалж, хуульчлах нь туйлын чухал юм.

- Төлөөлөлтэй байх эрх
- Үйлдэл хийх (үйл ажиллагаа явуулах)
- Мэдэх эрх

Төлөөлөлтэй байх эрх гэж юу вэ?

Монгол улсын иргэн сонгох, сонгогдох эрхтэй.

Монгол улсын Үндсэн хууль, 16.9-р зүйл



Таны төлөөлөлтэй байх эрх сонгох, сонгогдох эрх чөлөөгөөр дамжин хэрэгждэг. **Сонгуулийг шударга чөлөөтэй явуулахын тулд мэдээлэл чухал.**

Та өөрийн сонгосон төлөөллөөр дамжуулан төрийн хэрэгт шууд оролцно. Таны төлөөлөл УИХ, хот, дүүрэг, хороо, аймаг, сум, баг гээд бүх шатанд байдаг. Та сонгуульд оролцож, саналаа өгөхдөө аж амьдралаа дээшлүүлнэ гэж итгэж, өөрчлөлт хийхийн төлөө байдаг. Ийм учраас та улс төрийн нам, нэр дэвшигчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, амлалтыг сайтар судалж, биелэх магадлалтай эсэх талаар тунгаан бодох хэрэгтэй болно. Улсын ирээдүй танаас хамаарах учир та сонгуульд хайнга хандах ёсгүй. **Зөв сонголт хийхийн тулд танд мэдээлэл чухал.**

Жишээ: Нэр дэвшигч Дорж танай тойрогт сургууль байгуулахаар амлажээ. Үүнд нэлзэн хөрөнгө шаардлагатай нь мэдээж. Энэ бас таны хүсэл, хэрэгцээ гэж бодьё.

Асуулт: Энэ хөрөнгийг хаанаас олох вэ?

Хариулт: Улсын төсөвт суулгана

Хариулт тийм хангалттай бус байна. Улсын төсвийг УИХ-аар хэлэлцэх үед энэ тухай яригдах ажээ. Нэгэнт амлалт болохоор нэр дэвшигч сонгогдсон бол энэ асуудлыг төсөвт суулгахаар санал оруулж хэлэлцүүлэх нь. Харин батлагдах эсэх нь өнөөдөр тодорхойгүй учир амлалт биелэгдэнэ гэж итгэхэд магадлал бага юм.

Магадгүй танд танай хот, аймаг, сум, дүүрэг, багийн өнөөгийн төсөв, шинэ сургуультай болсноор нэмэгдэх төсвийн хэмжээ, шинэ сурагч, багшийн тоо зэрэг олон мэдээлэл шаардлагатай болох байх. Гэхдээ та зөв сонголт хийхийн тулд **эргэцүүлэн бодож, мэдээлэл цуглуулах хэрэгтэй.**

Жишээ: Тухайн тойрогт өрсөлдөж буй өөр нэг нэр дэвшигч “сонгогчдынхоо итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг амьдрал дээр бодитой хэрэгжих механизм бий болгох”-ыг амлав.

Энэ амлалт биелэгдвэл таныг өөр үзэл бодолтойн улмаас хэн ч ялгаварлан гадуурхахгүй, хавчиж дарамтлахгүй, шагналаас хасахгүй, ажлаас чинь халахгүй нь бололтой. Та аливаа дарамт шахалтгүйгээр бодсон санаснаа хэлж, ажил сайжруулахын төлөө шүүмжлэл өрнүүлж, удирдлагынхаа буруу шийдвэрийг эсэргүүцэж болох нь. Таны чөлөөтэй,

“Эсрэг талынхнаа сонсолгүй шийдвэр гаргаж байгаа хүн тэр шийдвэр нь шударга байлаа ч шударга бус алхам хийж байна”
Сенека

айдасгүй амьдрах нөхцөл бүрдэх нь. Та тунгаан бодохын тулд бусадтайгаа санал солилцож, мэдээлэл цуглуулах хэрэгтэй.

Байз, байз. Энэ хоёр нэр дэвшигч хоёулаа сайхан, хэрэгтэй зүйл амалж байна. Амлалтаа хэрхэн биелүүлэхийг хэмжих үзүүлэлт бүрхэг байна. Тэгвэл хэн нь илүү шударга, итгэл даах чадвартайг яаж мэдэх вэ? Үнэхээр миний төлөө ю, эсвэл өөрийн ашиг сонирхолдоо хөтлөгдөв үү? Аль хэр нэр хүндтэй хүн бэ? Аль хэр шударга хүн бэ? Урьд өмнө янз бүрийн хэрэг төвөг, хэл аманд өртөөгүй биз? **Мэдээлэл, мэдээлэл, мэдээлэл хэрэгтэй байна.**

Үйлдэл хийх эрх гэж юу вэ?

Монгол улсын иргэн нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураар эвлэлдэн нэгдэх эрхтэй

Монгол улсын Үндсэн хууль, 16.10-р зүйл

Үйлдэл хийх эрх нь цуглаанд оролцож, уг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, шийдвэр гаргагчдад хандан захидал илгээх, мэдэгдэл хийх, ухуулга хуудас хэвлэж тараах, хэвлэл мэдээлэлд хандах, хэвлэл мэдээллийн аян, жагсаал цуглаан зохион байгуулах, суулт хийх, ажил хаях, өлсгөлөн зарлах гэх мэт олон хэлбэрээр хэрэгжинэ. Та аливаа үйлдэл хийх, үйл ажиллагаа явуулахын тулд эвлэлдэн нэгдэх эрхтэй.

Эвлэлдэн нэгдэх эрх гэж ижил ашиг сонирхол, үзэл бодолтой хүмүүс хууль ёсны зорилгоор тэр засагт дуу хоолойгоо хүргэж, зохих шийдвэр гаргуулахын төлөө нэгдэж, хамтран ажиллахыг хэлнэ.



Жишээ нь: Эмч нар эвлэлдэн нэгдэв. Учир нь эмнэлгийн удирдлага эмчилгээний зардлыг багасгаж, өвчтөнүүдээс эм тариаг нь гаргах шийдвэр гаргаж, үүнийгээ төсөөв хүрэлцээгүй хэмээн тайлбарлав. Үүнийг эмч нар тангараг зөрчих, ёс зүйд харшлах шийдвэр гэж үзэж, эсэргүүцлээ илэрхийлэн тангараг зөрчих, ёс зүйд харшлах шийдвэр гэж үзэж, эсэргүүцлээ илэрхийлэн өргөх бичиг барив. Гэтэл удирдлага нь уг үйл ажиллагааг зохион байгуулсан эмч нарыг захиргааны шийдвэр эсэргүүцсэн хэмээн цалингаас нь хасах тушаал гаргав. Хариуд нь эмч нар төсвийн гүйцэтгэлд хяналт шалгалт хийгэжээ. Энэ явцад эмнэлгийн дарга төсвийн хөрөнгийг зүй бусаар ашигласан нь тогтоогджээ.

Монгол улсын иргэн нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураар эвлэлдэн нэгдэх эрхтэй

Монгол улсын Үндсэн хууль, 16.10-р зүйл

Таны сонгосон улс төрчид, тэдний томилсон албан тушаалтнууд буруу шийдвэр гаргаж, ард түмний аж амьдрал дээшлэхгүй бол, нийгэмд авлига, гэмт хэрэг зэрэг сөрөг үзэгдлүүд газар авч, олон нийт айдас хүйтэст автвал, төсвийн хөрөнгө зориулалтаараа зарцуулагдахгүй бол, албан тушаалтнууд эрх мэдлээ хэтрүүлэн, өөрийн эрх ашгийг илүүд чухалчилж байвал та шүүмжилж, эсэргүүцэх эрхтэй. **Ийм учраас танд мэдээлэл чухал.**

Жишээ: Танай байрны яг урьд шинэ барилга барьсны улмаас нарны гэрэл хаадаг болов. Энэ нь таны эрүүл мэндэд сайн биш. Та үүнийг эсэргүүцэхийн тулд буруу гэдгийг нотлох ёстой. Хоёр барилгын хоорондын зай ямар байх ёстой вэ? Үүнд ямар нэг дүрэм журам үйлчилж байж таарна. Та “Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” нэртэй баримт бичиг олж үзжээ. Эндээс олж авсан мэдээллээр хөршигдэхээ хуваалцаж, хамтран тэмцэхээр болов. Тэмцлийн явцад та тухайн газрыг тодорхой нэг эрх мэдэлтнийг хахуульдан олж авсныг олж илрүүлжээ.

Монгол улсын иргэн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх, уг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван замаар жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй.

Монгол улсын Үндсэн хууль, 16.17-р зүйл

Та аливаа асуудлаар төр засгийн анхаарлыг төвлөрүүлэх, үүнийхээ төлөө үгээ хэлэх, үзэл бодлоо илэрхийлэхээр тайван жагсаал цуглаан, уулзалт, чуулган зохион байгуулж болно. Энэ бүхний үндэслэл нь бодитой мэдээлэл байдаг.

Жишээ: Дээд сургуулийн захиргаа сургалтын төлбөрийг нэмэх шийдвэр гаргах гэж буйг оюутнууд олж мэджээ. Оюутны зөвлөл үүнийг эсэргүүцэн шалтгаанаа тайлбарлахыг шаардсан мэдэгдэл гаргасан боловч сургуулийн удирдлага үл тоомсорлов. Оюутны зөвлөл дахин хуралдаж, хичээлийн цагаар цуглаан зохион байгуулахаар шийдвэрлэжээ. Гэтэл сургуулийн захиргаа зохион байгуулагчдыг сургуулиас хасах шийдвэр гаргав. Энэ нь эсэргүүцлийн жагсаал болон өргөжсөн байна.

Мэдэх эрх гэж юу вэ?



Таны мэдээлэлтэй байх эрхийг **МЭДЭХ ЭРХ** гэж нэрлэдэг. Энэ эрх чөлөөгөө здэлснээр та жинхэнэ эрх мэдэлтэй болж, төрийг өөртөө үйлчлүүлэх механизмыг бодитой бүрдэнэ гэсэн уг. Мэдээлэлтэй байх нь үр өгөөжтэй, сайн засаглалын амин сүнс юм. Та мэдээлэлтэй болсноор улс оронд болж буй хэрэг явдлын талаар үнэн

“Дарангуйлал бол зуршил юм. Тэр хөгжих чадвартай, хөгжин хөгжсөөр өвчин болон хувирдаг“
Федор Достоевский

бодитой ойлголттой болж, нийгэмд ойлголцол, зөвшил бий болно. Үнэнийг худал цуу яриа, буруу ташаа мэдээллээс ялгаж ойлгох нь төр, иргэдийн хооронд түншлэл, итгэлцэл бий болоход чухал үүрэг гүйцэтгэнэ.

Таны МЭДЭХ ЭРХ бол Монгол Улсын Үндсэн Хуулиар баталгаажуулсан таны бусад эрх, эрх чөлөөгөө бүрэн эдлэх үндэс юм.

Би ямар хэлбэрээр мэдээлэл олж авч болох вэ?

Иргэд зөв, бодитой мэдээлэл олж авах олон хэлбэр байдаг. Тухайлбал:

- Мэдлэг, мэдээлэлтэй хүмүүс, тухайлбал иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчид, эрдэмтэн багш нар, нийгмийн зүтгэлтнүүд, УИХ-ын гишүүд, тэдний төлөөлөгчидтэй уулзах, асуулга, хүсэлт гаргаж хариулт авах;
- Тодорхой ажил, асуудал эрхэлж буй удирдах албан тушаалтан, ажилтан, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас мэдээлэл авах;
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээс мэдээлэл авах;
- Эх материал, лавлах, ном бусад эх сурвалж ашиглах. Номын сангүүд ямагт мэдээллийн сайн эх сурвалж болдог;
- Мэдээллийн эх сурвалжуудыг харьцуулах, үнэн бодитой эсэхийг шалгах;
- Бусад иргэдтэй маргаан мэтгэлцээн хийх;
- Бусад

Мэдээлэл надад ямар ач холбогдолтой вэ?

- 1) Хувь хүний нийгэмд байр сууриа эзлэх, өөртөө болон ирээдүйдээ итгэлтэй байх, өөрийгөө ойлгох, хөгжүүлэх;
- 2) Үнэнийг тунгаан бodoх, тодруулан ойлгох;
- 3) Эрх, эрх чөлөөгөө зохих ёсоор эдлэх;
- 4) Ажил хэргээ зөв баримжаалж, зохион байгуулах, аж байдлаа дээшлүүлэх;
- 5) Улс төр, нийгэм, эдийн засгийн үйл явцын талаар тодорхой төсөөлөл, ойлголттой байх;
- 6) Ардчилсан үйл явцад идэвхтэй оролцох;
- 7) Зөв шийдвэр гаргахад нөлөөлөх, ардчилсан, үр ашигтай удирдлагыг төлөвшүүлж, түүнд хувь нэмрээ оруулах;
- 8) Засаг, төрийн үйл ажиллагаанд олон түмэн, иргэний нийгмийн хяналт тогтоон хэрэгжүүлэх;
- 9) Шударга ёс хийгээд хууль дээдлэх ёсыг сахин хангах;
- 10) Эрх тэгш байх боломжоо ашиглах;
- 11) Засгийн газар бүрэн эрхийнхээ хугацаанд эрх мэдлээ хэтрүүлэх, урвуулахаас урьдчилан сэргийлэх;
- 12) Аливаа хууль бус явдалтай тэмцэхэд санаачилгатай оролцох;
- 13) Нийгэмд шударга ёсыг тогтоох

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГААС МЭДЭЭЛЭЛ ОЛЖ АВАХ ИРГЭНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ

**Иргэн нь мэдэх эрхтэй, мэдээллэлтэй
Ил тод төр, засаг хүчтэй!**

Төр, засаг мэдээллээс ил тод болгох үүрэг хүлээдэг үү?

Тийм ээ. Жинхэнэ ардчилсан, шударга, авлигаас ангид, нууцлах юмгүй цэвэр тунгалаг төр, засаг энэ үүргээ чандлан биелүүлнэ. Иргэдийнхээ мэдээлэл олж авахыг хуульчлан баталгаажуулах нь төрийн нэг үүрэг юм.

Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйл

Төрийн байгууллага Монгол улсын Үндсэн хуульд заасан иргэний эрх, эрх чөлөөгөө өдлэхэд чиглэсэн үйлчилгээ үзүүлдэг. Төрийн бүх үйлчилгээ иргэдэд хуулийн дагуу ил тод байх учиртай. Түүнчлэн, төрийн байгууллагаас түгээж байгаа мэдээлэл нь хүртээмжтэй, энгийн, ойлгомжтой байх ёстой.

Мэдээлэл олж авах эрх, эрх чөлөө нь эрүүл саруул хүнээр хязгаарлагдахгүй, хараагүй, сонсголгүй гэх мэтийн хөгжлийн бэрхшээлтэй, түүнчлэн амьдралын онцлогоос хамааран төв суурин газраас хязгаарлагдсан хүмүүст хамаарна.

“төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг хил хязгаарыг үл харгалzan амаар, бичгээр буюу хэвлэлээр, эсхүл уран сайхны хэлбэрээр, түүнчлэн өөрийн сонгосон бусад аргаар чөлөөтэй эрж хайх, хүлээн авах, түгээх эрхтэй”

**Иргэний болон Улс төрийн Эрхийн Олон Улсын Пактын
19 дүгээр зүйл**

Төр, засгийн байгууллагуудыг ардчилсан орнууд "олон нийтэд үйлчлэх байгууллага" гэж нэрлэдэг. Яамд, агентлаг гэх мэт засгийн газрын болон орон нутгийн засаг захиргааны байгууллага, төрийн санхүүжилт (олон нийтийн) бүхий бүх шатны сургууль, эмнэлэг зэрэг нь олон нийтэд өөрийн бодлого, шийдвэрийг таниулах үүрэгтэй.

Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайллан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй.

Монгол улсын Үндсэн хуулийн 16.17-р зүйл

“Хамгийн том боолчлол бол эрх чөлөөг олж аваагүй байж, өөрийгээ эрх чөлөөтэй гэж үзэх болой”
Иоган Вольфганг Гёте

Ийнхүү тайлагнахыг **ил тод байх зарчим** гэнэ. Энэ нь улс оронд юу болж буйг мэдэх боломжийг иргэдэд олгож, мэдээллийг нээлттэй байхыг шаарддаг юм. Энэ бол төр, засгийн ард түмнийхээ өмнө хүлээж буй том хариуцлага юм.

Төрийн байгууллагад ямар мэдээлэл хадгалагддаг вэ?

- Байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалтны тухай судалгаа, ажил үүргийн хуваарь, бодлогын тухай
- Байгууллагын шийдвэр, байгууллагын төсөв, түүний зарцуулалт
- Албан тушаалтнуудын эрх, үүрэг, ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолт
- Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам
- Иргэдэд зориулсан үйлчилгээний тухай тушаал, шийдвэр, дүрэм, журам
- Иргэдийн эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хангахтай холбоотой захидал, бичиг баримт
- Бусад



Мэдээлэл сайтай иргэд төрд ямар ач тустай вэ?

1. Албан тушаалтнууд авлигын гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлнэ;
2. Төсвийн хөрөнгө зориулагдсан зүйлдээ зарцуулагдаж эхэлнэ;
3. Төр, түүний байгууллагын үйл ажиллагаа ил тод байж, иргэд илүү мэдээлэлтэй болно;
4. Төр иргэдийнхээ хүсэл, зорилгын талаар илүү мэдээлэлтэй болно;
5. Төр иргэд болон төрийн бус байгууллагуудтай үр дүнтэй хамтран ажиллах боломжтой болно;
6. Төр олон нийттэй зөвшилцөх боломжтой болсноор амьдралд нийцэхүйц зөв шийдвэр гаргана;
7. Иргэд төрийн зөв бодлогыг үр дүнтэй дэмжинэ;
8. Улс төржсөн элдэв ярианд бодитой ханддаг болно;
9. Нийгмийн шударга ёс бэхжинэ.

Төрийн байгууллагаас иргэдэд зориулан түгээж буй мэдээлэл ямар байх ёстой вэ?

- Ямар ч хүн уншаад ойлгогдохоор энгийн;
- Мэргэжлийн хүнд нэр томъёо, уг хэллэг байхгүй /зөвхөн олон нийтэд зориулан хүргэж буй тохиолдолд/;

- Үйлчлүүлэгчдийн эрэлт, хэрэгцээнд тулгуурласан;
- Мэдээлэлтэй танилцах нөхцөл бүрэн хангагдсан /гэрэлтүүлэгтэй, уншиж болохоор гэх мэт/

Иргэд төрийн байгууллагын үйл ажиллагааны талаар мэдээллийг ямар аргаар олж авч байна вэ?

1. Байгууллагад өөрийн биеэр очиж хүсэлт гаргах;
2. Сургалт, семинарт суух;
3. Хэлэлцүүлэг, мэтгэлцээн хийх;
4. Бусдаас асууж, тодруулах, сонсох;
5. Хэвлэл мэдээллийн хэрэгслээс мэдээлэл олж үзэх, судлах;
6. Байгууллагын үйл ажиллагааны тайлан сонсох;
7. Хурал, чуулган д оролцох;
8. Бусад аргаар



Ямар мэдээллийг төрийн байгууллагаас авахыг хориглодог вэ?

- Хувь хүний нууцтай холбоотой мэдээлэл
- Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны явцын талаарх мэдээлэл
- Хяналт шалгалт явуулах үүрэг бүхий байгууллагад шалгагдаж байгаа асуудалтай холбоотой мэдээлэл
- Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд тусгагдсан мэдээлэл
- Төрийн өмчийт болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж шударга өрсөлдөөн, зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор нууцалж хамгаалсан мэдээлэл

Ямар мэдээллийг төрийн нууцад хамааруулдаг вэ?

Төрийн нууцад хамааруулах зүйлсийн жагсаалтыг хуулиар батална. Хууль гаргахгүйгээр аливаа мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг төрийн нууцад хамааруулахыг хориглодог.

Төрийн нууцын тухай хуулиар мэдээллийг доорхи хүрээнд нууцлахаар баталсан байдаг. Үүнд:

- а. Үндэсний аюулгүй байдал
- б. Батлан хамгаалах
- в. Эдийн засаг, шинжлэх ухаан, технологи
- г. Тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажил

Төрийн нууцын тухай хуульд "хууль гаргахгүйгээр аливаа мэдээ, баримт бичиг, биет зүйлийг төрийн нууцад (6.2) хамаарулахыг хориглодог" болохыг та мэдэж байх нь зүйтэй. Манай улсад мөн Төрийн нууцын жагсаалтыг батлах тухай хууль үйлчилж байгаа бөгөөд түүнд нийт 58 зүйлийг нууцлахаар хуульчилжээ.

Байгууллагын нууцыг хэрхэн тогтоодог вэ?

Байгууллагын нууцад хамаарах нууцыг Улсын Их Хурал хуулиар тогтоон баталгаажуулна. "Байгууллагын нууцын тухай хууль"-ийн 3 дугаар зүйлд "байгууллагын нууц" гэж хүний эрх, нэр төр, алдар хүнд тухайн байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор холбогдох хуулиар нууц гэж тогтоосон мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ" гэж тодорхойлсон.

Байгууллагын албан үйл ажиллагааны онцлогтой холбоотой, эсхүл шударга өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор байгууллага өөрөө нууцалж хамгаалалтдаа авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болох нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг байгууллагын нууцад хамааруулж болно.

Байгууллагын нууцын тухай хуулиар тухайн байгууллага өөрөө нууцаа тогтоодог бөгөөд нууцаа хамгаалах журмыг баталж мөрдөх үүрэгтэй.

Байгууллага ямар мэдээллийг нууцалж болохгүй вэ?

Таны хүссэн мэдээллийг өгөхгүй бол нууц мэдээллийн жагсаалттай танилцахыг хүсээрэй. Түүнд дээр дурьдсан олон улсын хэм хэмжээгээр зөвшөөрсөн хязгаарлалтаас бусад мэдээллийг нууцалсан ч байж болзошгүй. Учир нь нийгмийн шилжилтийн явцад хуучин соёл, уламжлалаас хараахан ангижирч чадаагүй байгаа тул удирдах ажилтан, албан хаагчид ч мэдээллийн чөлөө урсгал, ил тод зарчмын тухай ойлголт муутай байдаг. Энэ нь ихэнх тохиолдолд санамсаргүйгээр энгийн мэдээллийг ч нууцын ангилалд оруулахад хүргэдэг.



Байгууллагын нууц нь эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэхэд саад учруулахаар байж болохгүй.

Байгууллагын нууцын тухай хуулийн 6 дугаар зүйлд дараах мэдээллийг нууцалж болохгүй гэж заасан.

1/ тухайн байгууллагын явуулж

буй үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж буй техник, технологийн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийг илтгэн харуулах мэдээлэл;

2/ тухайн байгууллагын мэдэлд байгаа бөгөөд хадгалалт, хамгаалалтын горим нь зөрчигдсөн тохиолдолд хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болзошгүй бүх төрлийн хорт, цацраг идэвхт бодисын хор хөнөөлийг тодорхойлсон мэдээлэл;

3/ гэмт хэргийн тухай болон нийтэд мэдээлэхээр хуульд заасан бусад мэдээлэл.

Хувь хүний нууц гэж юу вэ?

Ардчилсан нийгэм бол иргэнийг (хувь хүнийг) дээдэлдэг тул хүний эрхийг баталгаажуулахдаа бусдын эрхийг зөрчихгүй байх үүднээс хязгаарлалт хийдэг. Ийм учраас манай улсад хүний хувийн нууцыг "Хувь хүний нууцын тухай хууль"-иар хамгаалсан. Энэ хуульд "задруулбал тухай хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хувь хүний нууц гэнэ" гэж тодорхойлсон.

Хувь хүний нууц дараах төрөлтэй:

- Захидал харилцааны
- Эрүүл мэндийн
- Гэр бүлийн
- Эд хөрөнгийн /төрийн албан хаагчийн хувьд хөрөнгө, орлогынх нь талаарх мэдээллийг чөлөөтэй авах эрхтэй/

“МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ” ХУУЛЬ

**Төрийн байгууллагад хадгалагдаж буй
мэдээлэл бол ард түмний өмч**



2011 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хууль батлагдаж 12 дугаар сарын 01-ний өдрөөс бүрэн хэрэгжиж эхэлснээр

- Төрийн байгууллагуудад мэдээллээ нээлттэй байх үүрэг ногдуулж
- Иргэн, хуулийн этгээд төрийн байгууллагаас мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан юм.

“Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хууль төрийн ямар байгууллагуудад хамаарах вэ?

Энэ хууль нь улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг дараах байгууллагад хамаарна. Үүнд:

- Улсын Их Хурлын Тамгын газар;
- Ерөнхийлөгчийн Тамгын газар;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газар;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба;
- төрийн захиргааны төв болон бусад төрийн захиргааны байгууллага;
- бүх шатны шүүх, прокурорын байгууллага;
- Улсын Их Хурлаас байгуулдаг /Засгийн газраас бусад/ байгууллага;
- нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын ажлын алба, орон нутгийн өмчтэй болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;
- төрийн өмчтэй болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллага;
- Олон нийтийн радио, телевизийн байгууллага

Төрийн байгууллагуудад ямар мэдээллийг ил тод байлгах үүрэг ногдуулсан бэ?

Энэ хуулийн 6-р зүйлд төрийн байгууллагад дараах дөрвөн төрлийн мэдээллийг нээлттэй болгохыг үүрэг болгосон байна. Үүнд:

- үйл ажиллагаа
- хүний нөөц
- төсөв, санхүү
- төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа

Хуулийн 7, 8, 9, 10 дугаарт зүйлд дээрх төрлийн мэдээллийн ил тод байдлыг хангахад авах арга хэмжээнүүдийг тус бүрд нь дэлгэрэнгүй заасан байна.

Төрийн байгууллагууд дээрх мэдээллүүдийг олон нийтэд хэрхэн нээлттэй, ил тод болгох вэ?

Хуульд зааснаар төрийн байгууллагууд олон нийтэд нээлттэй, ил тод байлгах мэдээллийг байгуулагын

- 
- цахим хуудас
 - мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчилж байх үүрэгтэй.

Мэдээлэл нь олон нийтийг мэдээлэлтэй танилцах нөхцөл бүрэн хангагдсан байх бөгөөд тухайн мэдээллийг 14 хоног тутам нэгээс доошгүй удаа шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт орсон, эсхүл мэдээлэл бүхэлдээ өөрчлөгдсөн тохиолдолд уг мэдээллийг 3 хоногийн дотор шинэчилж байхыг үүрэг болгосон байна.

Би төрийн байгууллагаас ямар мэдээлэл авах эрхтэй вэ?

Энэ хуулийн 3.1-д заасан байгууллагуудаас дараах мэдээллийг авах эрхтэй. Үүнд:

- Тухайн байгууллагын эзэмшилд байгаа бүх төрлийн мэдээ, баримт бичиг, гэрээ, контракттай холбоотой мэдээлэл
- Тухайн байгууллагын эзэмшилд байгаа эд зүйлтэй холбоотой мэдээлэл
- Тухай байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээлэл

Би мэдээлэл авах тухай хүсэлтээ хэрхэн гаргах вэ?

Төрийн байгууллагаас мэдээлэл авах хүсэлт гаргасан иргэн:

- эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр,



- оршин суугаа газрын буюу цахим шуудангийн хаяг, утасны дугаар,
- иргэний үнэмлэх, эсхүл түүнтэй адилтгах бичиг баримтын дугаарыг бичиж, гарын үсэг зурсан байна.

Харин хуулийн этгээд:

- нэр, хаяг буюу цахим шуудангийн хаяг,
- улсын бүртгэлийн дугаараа бичиж, хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээдийн гарын үсэг

Мэдээлэл авах тухай иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авч байгаа албан тушаалтан энэ хуульд зааснаас бусад шаардлага тавихыг хориглоно (11.2).

Мэдээлэл хүсэж буй иргэн ямар эрхтэй вэ?

Хуулийн 12.1 зүйлд төрийн байгууллагаас мэдээлэл авахыг хүсэж буй иргэн, хуулийн этгээд дараах эрхтэй.

- Эрх тэгш байх
- Мэдээлэл авах хэлбэрээ сонгох
- Мэдээлэл авах шаардлага, үндэслэлээ тайлбарлахгүй байх
- Нэмэлт лавлагaa авах
- Агуулгын талаар амаар тайлбарлуулах
- Албан ёсны эх сурвалжийг мэдэх
- Мэдээлэл авах эрх зөрчигдсөн гэж үзвэл эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах
- Хуульд заасан бусад эрх



Би мэдээлэл авах хүсэлт гаргахдаа шалтгаанаа тайлбарлах ёстой ю?

Тайлбарлах албагүй. Та мэдээлэл авах болсон шаардлага, үндэслэлээ тайлбарлахгүй байх эрхтэй. Мөн мэдээлэлтэй холбогдсон асуудлаар нэмэлт лавлагаа авах; агуулгын талаар амаар тайлбарлуулах; албан ёсны эх сурвалжийг мэдэх эрхтэй.

/Хуулийн 12.1/

Харин хуулийн 12.2 зүйлд зааснаар

- хуульд заасан мэдээлэл авах журмыг биелүүлэх;
- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх;
- авах мэдээллээ бодитой тодор-хойлсон байх үүрэг хүлээнэ.

Миний хүсэлтийг ямар тохиолдолд буцаах вэ?

Мэдээлэл авах тухай иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авсан албан тушаалтан дараах 2 тохиолдолд буцааж болно.

- 11.3-д заасан шаардлага буюу эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын буюу цахим шуудангийн хаяг, утасны дугаар, иргэний үнэмлэх, эсхүл түүнтэй адилтгах бичиг баримтын дугаарыг бичиж, гарын үсэг зурсан байх шаардлагыг хангаагүй бол

- Хүссэн мэдээлэл тухайн байгууллагын эзэмшилд байхгүй, хүсэлтийг өөр байгууллагад шилжүүлэх боломжгүй бол хүсэлтийг буцаана.

Би хүссэн мэдээллээ ямар хэлбэрээр авч болох вэ?

Мэдээлэл хүсэгч нь мэдээлэл авах хэлбэрээ сонгох эрхтэй /Хуулийн 12.1 зүйл/

Хүссэн мэдээллээ амаар, бичгээр, цахим хэлбэрээр авч болно. Мөн мэдээлэлтэй биечлэн танилцаж болно.

Миний мэдээлэл авах хүсэлтэнд ямар хугацаанд хариу өгөх вэ?

Хариуг шууд өгөх боломжтой хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж хариуг өгнө. Хуульд өөрөөр заагаагүй бол ажлын 7 өдрийн дотор өгнө. Шаардлагатай гэж үзвэл энэ хугацааг нэг удаа 7 хоногоор сунгаж болно.

Би мэдээлэл авсныхаа төлөө төлбөр төлөх үү?

Үйлчилгээний хөлс төлнө. Монголын Засгийн газрын 2013 оны 2013 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 54 дүгээр тогтоолоор баталсан “Мэдээлэл өгөх үйлчилгээний хөлс төлөх, түүнээс хөнгөлөх, чөлөөлөх журам”-аар үйлчилгээний хөлсний жишиг хэмжээг дараах байдлаар тооцсон. Үүнд:

А-4 (нэг тал) нэг хуудас мэдээлэл хэвлэх-50 төгрөг

А-4 (нэг тал) нэг хуудас мэдээлэл хувилах-25 төгрөг



Тухайн байгууллага дээрх үнийг зах зээлийн үнийн өөрчлөлтэй уялдуулан өөрчлөн тогтоож болно. Үйлчилгээний хөлс нь уг мэдээллийг өгөхтэй холбогдон гарах хэвлэх, хувилах, шуудангаар хүргүүлэх зэрэг шууд зардлаас хэтэрч болохгүй. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчилгээний хөлс төлөхгүй.

Надад мэдээлэл өгөхөөс татгалзсан төрийн албан хаагчийн талаар гомдол гаргаж болох уу?

Болно. Хуулийн 17 дугаар зүйлд зааснаар иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл авах эрхийг зөрчсөн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдлийн талаар

- Дээд шатны байгууллага, албан тушаалтан,
- Хүний эрхийн Үндэсний Комисс, эсхүл
- Шүүхэд гомдол гаргаж болно.

Надад мэдээлэл өгөөгүй байгууллага, албан тушаалтанд ямар хариуцлага хүлээлгэх вэ?

Мэдээлэл өгөөгүй төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулна. Иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл авах эрхийг гурав буюу түүнээс дээш удаа зөрчсөн, мөн хууль бусаар мэдээллийг нуун дарагдуулах, мэдээ, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, засварлах, устгах болон иргэний мэдээлэл авах эрхийг бусад хэлбэрээр зөрчсөн нь төр, иргэн, аж ахуйн нэгж, бусад байгууллагад их хэмжээний хохирол учруулсан буюу учруулж болох байсан нөхцөлд албан хаагчийг эрх бүхий этгээд төрийн албанаас хална.

Харин шийдвэр гаргах эрх бүхий этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Төрийн байгууллагуудад ямар мэдээллийг олон нийтэд нээлттэй илтод байлгахыг хориглосон бэ?

Хуулийн 4 дүгээр бүлэгт зарим төрлийн мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд өгөхийг хориглосон. Үүнд:

- Үндэсний аюулгүй байдал, нийтийн эрх ашигт хохирол учруулах бодит үндэслэл
- Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо, өрсөлдөөний болон мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шалгагдаж буй асуудалтай холбоотой бол
- Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны явцад төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах шаардлагатай бол
- Олон улсын гэрээ хэлэлцээр, байгуулах явцтай холбоотой бол
- Хууль тогтоомжид заасан бусад
- Оюуны өмчтэй холбоотой мэдээллийг өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр задлах
- Хувь хүн бичгээр зөвшөөрсөнөөс бусад тохиолдолд түүний нэр, нас, хүйс, мэргэжил, боловсрол, албан тушаал, ажлын газрын хаяг, ажлын утаснаас бусад мэдээллийг бусдад задруулах
- Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой, эсхүл шударга өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор нууцалж, хамгаалалтдаа авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд хор уршиг учруулж болох нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжтэй холбоотой мэдээллийг эрх бүхий этгээдийн бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГТЭЙ ТАНИЛЦАХ ЭРХ

Би албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлэгтэй танилцах эрхтэй юу?

Та хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх хадгалах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хандан албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлэгтэй танилцах эрхтэй.

Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй танилцах нь ямар ач холбогдолтой вэ?

Төрийн албан хаагчийн хөрөнгө, орлогын бодит байдлыг хөрөнгө орлогын мэдүүлэгт хэрхэн тусгасан байгаатай харьцуулан үзсэнээр дараах ач холбогдолтой:

- Төрийн албан хаагч хууль бусаар хөрөнгөжиж байгаа, илрүүлэх
- Авлигын гэмт хэргийг илрүүлэх



Албан тушаалтан хөрөнгө, орлогын мэдүүлгээ хэдийд гаргаж өгөх үүрэгтэй вэ?

Албан тушаалтан хөрөнгө, орлогын мэдүүлгээ албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн алба хааж байгаа хугацаандaa жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж энэ хуулийн Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй. Төрийн албан хаагчийн хөрөнгө, орлогод их хэмжээний өөрчлөлт орсон бол түүнийг 30 хоногийн дотор мэдэгдэж бүртгүүлнэ. / Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.5, 10.6/

Би албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй танилцах хүсэлтээ хаана, хэнд гаргах вэ?

Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар хөрөнгө, орлогын мэдүүлгийг дараах байгууллага, албан тушаалтан хуульд заасан хугацаанд бүртгэж, хадгална. Иймд дараах байгууллагад хандан тодорхой албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг үзэж танилцах, холбогдох мэдээлэл авч болно.

- Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, түүнчлэн Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч,

Засгийн газраас томилогддог албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар;

- Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо;
- Үндсэн хуулийн цэцийн гишүүн болон бүх шатны шүүхийн шүүгчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг Шүүхийн ерөнхий зөвлөл;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба;
- Бусад албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтан

Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг ямар байдлаар олон нийтэд мэдээлдэг вэ?

1. Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргагчийн овог, нэр, албан тушаалын байдал.
2. Хөрөнгө, орлогын мэдүүлгийн “Орлого” хэсэгт мэдүүлэг гаргагчийн болон хамт амьдарч байгаа гэр бүлийн гишүүдийн тухайн жилд олсон нийт орлогын дүн.
3. “Хөрөнгө, зээл, бэлэг” хэсэгт “Барилга байгууламж”, “Авто тээврийн хэрэгсэл”, “Мал”, “Газар”, “Эрх, концесс, лиценз” гэсэн үзүүлэлтийн тус бүрийн зориулалт, төрөл, тоо хэмжээ, үнийн дүн.
4. Мөн хэсгийн “Хадгаламж”-ийн жилийн эцсийн үлдэгдлийн төгрөгөөр илэрхийлсэн дүн.
5. Мөн хэсгийн “Хөрөнгө оруулалт, хувьцаа” үзүүлэлтээс мэдүүлэг гаргагчийн болон түүний гэр бүлийн гишүүдийн хөрөнгө оруулалт хийж хувь оруулсан хуулийн этгээдийн нэр, эзэмшлийн хувь хэмжээ, хувьцааны тоо ширхэг, хөрөнгө оруулалтын нийт дүн.
6. Мөн хэсгийн “Зээл”-ийн зээлдүүлэгчийн нэр, зээлийн дүн, “Бэлэг”-ийн эх сурвалжийн нэр, нийт үнийн дүн.



Нийтийн албан тушаалтан ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ мэдэгдэх үүрэгтэй ю?

Нийтийн алба хашиж байгаа болон тэдгээр албанад томилогдоо нэр дэвшсэн этгээд УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос баталсан маягтын дагуу хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ өөрөө, үнэн зөв гаргах үүргийг хуулиар ногдуулсан.

Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэгтэй танилцах нь ямар ач холбогдолтой вэ?

Төрийн албан хаагчийн хувийн ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэгтэй танилцсанаар тухайн төрийн албан хаагч захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох явцад төр, нийтийн эрх ашгаас хувийн ашиг сонирхлыг илүүд үзэж байгаа эсэхэд хяналт тавих боломжтой.

Ямар албан тушаалтнууд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах вэ?

Дараах албан тушаалтанууд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргана:

- төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;
- төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан;
- төрийн болон орон нутгийн өмчт, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан;
- хууль тогтоомжийн дагуу, эсхүл улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг түр буюу байнга гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;
- хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах албан тушаалтын жагсаалтад орсон албан тушаалтан.

/Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4 дүгээр зүйл/

Би албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэгтэй танилцах эрхтэй юу?

Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг нээлттэй байна.

Энэ хуулийн 24.1-д заасан байгууллага, албан тушаалтан цргэдийг албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэгтэй саадгүй танилцах боломжоор хангах үүрэгтэй.

Нийтийн албанд нийтийн болон хувийг ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 25 дугаар зүйлээс

Би албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэгтэй танилцахыг хүсвэл хаана, хэнд хандах вэ?

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг олон нийтэд нээлттэй бөгөөд тодорхой байгууллага, албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын байдалд хяналт тавих боломж ийнхүү хуулиар олгогдсон байна. Иймд дараах байгууллагад хандан тодорхой албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг үзэж танилцах, холбогдох мэдээлэл авах өргөн боломжтой. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд,

Засгийн газрын гишүүн, түүнчлэн Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газраас томилогддог албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн талаар Авлигатай тэмцэх газарт

- Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн талаар Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд
- Үндсэн хуулийн цэцийн гишүүн болон бүх шатны шүүхийн шүүгчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн талаар Шүүхийн ерөнхий зөвлөлд
- аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн талаар тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд
- бусад албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтанд хандана.

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэгтэй холбоотой гомдол, мэдээллийг ямар байгууллага шалгах вэ?

Улсын Их Хурлын гишүүний хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг иргэний өргөдөл, гомдолд үндэслэн Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хороо шалгана.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсарч байгаа бол тухайн гишүүний хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар шалгана.

МЭДЭЭЛЭЛ ОЛЖ АВАХ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ ЗӨРЧИГДСӨН ГЭЖ ҮЗВЭЛ ГОМДОЛ ГАРГАХ ЭРХ

Иргэдэд мэдээлэл өгөх үйл ажиллагаатай холбоотойгоор төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргах өргөдөл, гомдол гэж юу вэ?



"өргөдөл" гэж төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөнөөс бусад асуудлаар төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан хүсэлтийг; Өргөдөл нь санал, мэдэгдлийн шинжтэй байж болно.

"санал" гэж төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гаргасан иргэний хүсэлтийг;

"мэдэгдэл" гэж Үндсэн хууль, бусад хууль тогтооомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэдээс гаргасан хүсэлтийг

"гомдол" гэж төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлтийг тус тус хэлнэ.

Ямар тохиолдолд өргөдөл, гомдлыг хүлээн авч, хянан үзэхгүй вэ?

- 1/ өргөдөл, гомдол нь тодорхой нэр хаяггүй;
- 2/ бага насны хүмүүс буюу шүүхийн шийдвэрээр эрхийн бүрэн чадамжгүйд тооцогдсон этгээд эцэг, эх, асран хамгаалагчаараа төлөөлүүлээгүй бол;
- 3/ төрийн тухайн байгууллага, албан тушаалтанд иргэн өмнө нь хандаж байсан асуудлаар өргөдөл, гомдол гаргасан бөгөөд түүнийг дахин хянаж шийдвэрлэх үндэслэлгүй;
- 4/ өргөдөл, гомдолд дурдсан асуудлаар шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр байгаа.

Өргөдөл, гомдлын талаар төрийн байгууллага, албан тушаалтан ямар нийтлэг үүрэг хүлээх вэ?

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлд энэ талаар хуульчилсан байдаг. Үүнд:

- 1) иргэдээс өргөдөл, гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэх нөхцлийг бүрэн хангах;
- 2) харьяаллын дагуу ирсэн өргөдөл, гомдлыг заавал хүлээн авах;
- 3) өргөдөл, гомдолд дурдсан асуудал бүрийг эрх хэмжээнийхээ хүрээнд хянан үзэж, үндэслэлтэй шийдвэрлэх;

- 4) өргөдөл, гомдлыг хугацаанд нь барагдуулах;
 - 5) өргөдөл, гомдолд дурдсан төр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах;
 - 6) өргөдөл, гомдолд үндэслэл бүхий хариу өгөх;
 - 7) өргөдөл, гомдлын талаар гаргасан шийдвэрийн дагуу харьяа байгууллага, доод шатны албан тушаалтны авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг шалгах;
 - 8) иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаархи мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлэх;
 - 9) хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчлах.
2. Тухайн байгууллага, албан тушаалтан өөрийн эрх хэмжээнд хамаарах өргөдөл, гомдлыг үндэслэлгүйгээр өөр байгууллага, албан тушаалтанд шилжүүлж болохгүй

Гомдол хэрхэн гаргах вэ?

Иргэн, хуулийн этгээд дангаараа болон хэд хэдэн хүн, хуулийн этгээд хамтарч гомдол гаргаж болно. Түүнчлэн төлөөлөгч буюу өмгөөлөгчөөр дамжуулан гомдол гаргах эрхтэй.

Өргөдөл, гомдол гаргагч ямар эрхтэй вэ?

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлд

- 1/ гаргасан өргөдөл, гомдлынхоо хариуг авах;
- 2/ өргөдөл, гомдолтойгоо холбогдуулж тайлбар, нотлох баримт гаргах;
- 3/ өргөдөл, гомдоосоо татгалзаж буцаан авах;
- 4/ өгсөн хариуг зөвшөөрөөгүй тохиолдолд зохих дээд шатны албан тушаалтанд гомдол гаргах;
- 5/ төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдоо шийдвэрлүүлэх эрхтэй гэж заасан.

Надад мэдээлэл өгөхөөс татгалзвал гомдол гаргаж болох уу?

Иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл авах эрхийг зөрчсөн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдлийн талаар

- Дээд шатны байгууллага, албан тушаалтан,
- Хүний эрхийн Үндэсний Комисс, эсхүл
- Шүүхэд гомдол гаргаж болно.(Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйл)

Төрийн байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах (Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйл)

Гомдол дараах зүйлийг тусгана:

1. Бичгээр гаргасан өргөдөл, гомдолд овог, нэр оршин суугаа газрын буюу шуудангийн хаягаа бичиж, гарын үсгээ зурна. Хүндэтгэн үзэх шалтгаанаар гарын үсгээ зурж чадахгүй бол бусдаар төлөөлүүлэн зурж болно.
2. Өргөдөл, гомдлыг иргэд бичгээр хамтран гаргасан бол түүнд бүгд гарын үсэг зурах буюу эсхүл тэдгээрийн төлөөлөгч гарын үсэг зурж, төлөөлөх эрхээ нотлох баримт бичгийг хавсаргана.
3. Өргөдөл, гомдол гаргахад энэ зүйлд зааснаас бусад зүйл шаардахыг хориглоно.

Хүний эрхийн Үндэсний комисст гомдол гаргах (Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуулийн 11 дүгээр зүйл)

Гомдолд дараах зүйлийг тусгасан байна:

- Гомдол гаргагч гомдлоо захиргааны журмаар шийдвэрлүүлсэн байх;
- Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан ямар эрх, эрх чөлөөнь зөрчигдсөн болохыг заах;
- Гомдол гаргагч өөрийн нэр, оршин суугаа газрын буюу шуудангийн хаягаа бичиж, гарын үсгээ зурсан байх;
- Гомдолд холбогдож байгаа аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүний нэр, хаяг, утасны дугаар холбогдох бусад баримтыг хавсаргасан байх. Комиссын гишүүн нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шатанд байгаа болон хянан шийдвэрлэгдсэн эрүү, иргэний хэрэг, маргааны талаархи гомдлыг хүлээн авахгүй.

Захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргах (Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйл)

Нэхэмжлэлд дараах зүйлийг тусгана:

- нэхэмжлэлийг захиргааны хэргийн ямар шүүхэд гаргаж байгаа;
- нэхэмжлэгч, хариуцагчийн овог, эцгийн болон өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, хуулийн этгээд бол нэр, оршин байгаа газрын хаяг;
- нэхэмжлэлийн шаардлагын агуулга;
- хавсаргасан баримт бичгийн жагсаалт.
- Нэхэмжлэлийг төлөөлөгч гаргасан бол итгэмжлэл буюу гэрээг хавсаргана.
- Нэхэмжлэлд нэхэмжлэгч, эсхүл төлөөлөгч гарын үсэг зурж, нэхэмжлэл болон түүнд хавсаргасан баримт бичгийг хариуцагчийн тоогоор хувилж өгнө.
- Энэ хуулийн 32.2.3-т заасан нэхэмжлэлийн шаардлагын агуулга гэдэгт дараах зүйлийн аль нэг багтана:
- захиргааны байгууллагаас гаргасан захиргааны акт нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөнийг нотолж чадах бол тухайн актыг хүчингүй болгуулах; 32.5.2. захиргааны байгууллагаас гаргасан захиргааны акт илт хууль бус гэдгийг хүлээн зөвшөөрүүлэх;

- маргаан бүхий захиргааны акт нэхэмжлэгчийн ямар эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн болон түүнээс үүдэн гарах хохирлын тухай;
- захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус эс үйлдэхүй нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хэрхэн зөрчсөн, түүний үр дагаврыг арилгах тухай зааж, зөрчигдсөн эрхээ хэрхэн сэргээлгэхийг хүсч байгаа.

Иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл авах эрхийг зөрчсөн байгууллага, албан тушаалтанд ямар хариуцлага хүлээлгэх вэ?

Мэдээлэл өгөөгүй төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулна. Иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл авах эрхийг гурав буюу түүнээс дээш удаа зөрчсөн, мөн хууль бусаар мэдээллийг нуун дарагдуулах, мэдээ, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, засварлах, устгах болон иргэний мэдээлэл авах эрхийг бусад хэлбэрээр зөрчсөн нь төр, иргэн, аж ахуйн нэгж, бусад байгууллагад их хэмжээний хохирол учруулсан буюу учруулж болох байсан нөхцөлд албан хаагчийг эрх бүхий этгээд төрийн албанаас хална.

Харин шийдвэр гаргах эрх бүхий этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ
2011 оны 06 сарын 16 өдөр

**МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ
 АВАХ ЭРХИЙН ТУХАЙ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
 НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь төрийн үйл ажиллагааны ил тод байдал болон иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомж

2.1. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Төрийн нууцын тухай², Төрийн нууцын жагсаалт батлах тухай³, Хувь хүний нууцын тухай⁴, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хууль нь улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг дараах байгууллагад хамаарна:

- 3.1.1. Улсын Их Хурлын Тамгын газар;
- 3.1.2. Ерөнхийлөгчийн Тамгын газар;
- 3.1.3. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар;

¹ Монгол Улсын Үндсэн хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

² Төрийн нууцын тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1995 оны 7 дугаарт нийтлэгдсэн

³ Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2004 оны 4 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Хувь хүний нууцын тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1995 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

- 3.1.4. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба;
 - 3.1.5. төрийн захиргааны төв болон бусад төрийн захиргааны байгууллага;
 - 3.1.6. бүх шатны шүүх, прокурорын байгууллага;
 - 3.1.7. Улсын Их Хурлаас байгуулдаг /Засгийн газраас бусад/ байгууллага;
 - 3.1.8. нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын ажлын алба, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;
 - 3.1.9. төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;
 - 3.1.10. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн⁵ 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллага;
 - 3.1.11. олон нийтийн радио, телевизийн байгууллага.
- 3.2. Зэвсэгт хүчин, хилийн болон дотоодын цэрэг, тагнуулын байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангахад энэ хууль үйлчлэхгүй.
- 3.3. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай⁶ хуулийн 4 дүгээр зүйлд заасан өргөдөл, санал, гомдол, мэдэгдлийг, хүлээн авах, хянан шийдвэрлэхэд энэ хууль үйлчлэхгүй.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

- 4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:
- 4.1.1. “иргэн” гэж Монгол Улсын иргэн, Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг;
 - 4.1.2. “цахим хуудас” гэж нийтэд нээлттэй байдлаар интернэт сүлжээнд байрлуулсан цахим баримт бичиг, мэдээллийг;
 - 4.1.3. “цахим баримт бичиг” гэж компьютер, компьютерийн программ болон ижил төрлийн бусад хэрэгслийг ашиглан үүсгэх, илгээх, хүлээн авах, хадгалах боломжтой цахим өгөгдлийг;
 - 4.1.4. “тоон гарын үсэг” гэж цахим баримт бичгийг хуурамчаар үйлдэх, өөрчлөхөөс хамгаалах зорилгоор тоон гарын үсгийн хувийн түлхүүр ашиглан мэдээллийг криптограф хувиргалтад оруулж үүсгэсэн, уг баримт бичгийн нэг бүрдэл хэсэг болох тоон өгөгдлийг;
 - 4.1.5. “тогтмол шинэчлэх” гэж тухайн мэдээллийг 14 хоног тутам нэгээс доошгүй удаа шинэчлэхийг;
 - 4.1.6. “тухай бүр шинэчлэх” гэж тухайн мэдээлэлд нэмэлт, өөрчлөлт орсон, эсхүл мэдээлэл бүхэлдээ өөрчлөгдсөн тохиолдолд уг мэдээллийг 3 хоногийн дотор шинэчлэхийг;

⁵ Монгол Улсын Засгийн газрын тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1993 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

⁶ Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1995 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

- 4.1.7. “оилгомжтой байдлаар байрлуулах” гэж тухайн мэдээлэлтэй танилцах нэхцэл бүрэн хангагдсан байхыг;
- 4.1.8. “мэдээлэл өгөх зардал” гэж мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд өгөх зорилгоор хувилах, олшруулах, шуудангаар хүргүүлэх болон бусад шаардлагатай зардлыг;
- 4.1.9. “удаа дараа зөрчсөн” гэж мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийг гурав буюу түүнээс дээш удаа зөрчсөнийг;
- 4.1.10. “ноцтой зөрчсөн” гэж хууль бусаар мэдээллийг нуун дарагдуулах, мэдээ, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, засварлах, устгах болон иргэний мэдээлэл авах эрхийг бусад хэлбэрээр зөрчсөн нь төр, иргэн, аж ахуйн нэгж, бусад байгууллагад их хэмжээний хохирол учруулсан буюу учруулж болох байсан зэргийг.

5 дугаар зүйл. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийг хангах үйл ажиллагаанд баримтлах зарчим

- 5.1. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийг хангах үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:
 - 5.1.1. хууль дээдлэх;
 - 5.1.2. иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;
 - 5.1.3. хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх;
 - 5.1.4. хараат бус байх;
 - 5.1.5. мэдээллээр хангах үйл ажиллагаа шуурхай байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ
МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

6 дугаар зүйл.Мэдээллийн ил тод байдал

6.1. Мэдээллийн ил тод байдал дараах төрөлтэй байна:

- 6.1.1. үйл ажиллагааны ил тод байдал;
- 6.1.2. хүний нөөцийн ил тод байдал;
- 6.1.3. төсөв, санхүүгийн ил тод байдал;
- 6.1.4. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ ахудалдан авах ажиллагааны ил тод байдал.

7 дугаар зүйл.Үйл ажиллагааны ил тод байдал

7.1. Энэ хуулийн 3.1-д заасан байгууллага нь хуульд өөрөөр заагаагүй бол үйл ажиллагааныхаа ил тод байдлыг хангах чиглэлээр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:

- 7.1.1. эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартaa ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;
- 7.1.2. үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартaa ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;
- 7.1.3. үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартaa ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;
- 7.1.4. үйл ажиллагаандaa мөрдөх байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартaa ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;
- 7.1.5. шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;
- 7.1.6. үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- 7.1.7. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд

тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;

- 7.1.8. тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандaa ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;
- 7.1.9. салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандaa байрлуулан тухай бүр шинэчлэх;
- 7.1.10. хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл.

8 дугаар зүйл. Хүний нөөцийн ил тод байдал

- 8.1. Энэ хуулийн 3.1-д заасан байгууллага нь хуульд өөрөөр заагаагүй бол хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:
 - 8.1.1. сүл орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;
 - 8.1.2. албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;
 - 8.1.3. хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандaa ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;
 - 8.1.4. хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандaa ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;
 - 8.1.5. албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандaa ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;
 - 8.1.6. хууль тогтоомжид заасан бусад мэдээллийг мэдээлэх.

9 дүгээр зүйл. Төсөв, санхүүгийн ил тод байдал

- 9.1. Энэ хуулийн 3.1-д заасан байгууллага нь хуульд өөрөөр заагаагүй бол төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах чиглэлээр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:
 - 9.1.1. тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төслийг өөрийн цахим хуудас болон Монгол Улсын төсвийн ил тод байдал цахим хуудсанд дор дурдсан хугацаанд байрлуулан мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлэх:

- 9.1.1.а. тухайн жилийн төсвийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;
- 9.1.1.б. өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор;
- 9.1.1.в. дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор.
- 9.1.2. жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор цахим хуудас болон мэдээллийн самбартaa ойлгомжтой байдлаар байрлуулан иргэд, иргэний нийгмийн байгууллагын зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг хангах;
- 9.1.3. санхүүгийн тайланд нь хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор цахим хуудас болон мэдээллийн самбартaa ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;
- 9.1.4. тухайн жилийн төсөвт нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд ажлын 14 өдрийн дотор энэ тухай цахим хуудас болон мэдээллийн самбартaa ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;
- 9.1.5. зөвхөн хууль тогтоомжид заасантөлбөр, хураамжийгүйлчлүүлэгчээс авч, түүний хэмжээг цахим хуудас болон мэдээллийн самбартaa ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;
- 9.1.6. хууль тогтоомжид заасан бусад мэдээллийг мэдээлэх.
- 9.2. Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 7, 8 дугаар зүйл, 9.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлд зааснаас гадна дараах мэдээллийг үндэсний хэмжээний өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээж, цахим хуудас болон мэдээллийн самбартaa ойлгомжтой байдлаар байрлуулна:
- 9.2.1. концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батлагдсанаас нь хойш ажлын 14 өдрийн дотор;
- 9.2.2. концессын гэрээ болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг байгуулагдсанаас нь хойш ажлын 14 өдрийн дотор;
- 9.2.3. концессын гэрээ байгуулсан тухай бүрд концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг ажлын 14 өдрийн дотор.
- 9.3. Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон бусад төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 7, 8 дугаар зүйл, 9.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлд зааснаас гадна нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсандaa ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэнэ.

10 дугаар зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал

- 10.1. Энэ хуулийн 3.1-д заасан байгууллага нь хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах чиглэлээр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:
- 10.1.1. ил тод, шударга, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд сууринсан худалдан авах ажиллагааны бодлого баримтлан, энэ тухай цахим хуудсандaa байрлуулах болон бусад хэлбэрээр нийтэд мэдээлэх;
 - 10.1.2. тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байрлуулан тухай бүр шинэчлэх, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн⁷ 21 дүгээр зүйлд заасны дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх;
 - 10.1.3. тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;
 - 10.1.4. тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээллийг цахим хуудсандaa байрлуулан тухай бүр шинэчлэх, шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар тодорхой танилцуулах;
 - 10.1.5. худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг цахим хуудсандaa байршуулан тухай бүр шинэчлэх;
 - 10.1.6. тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлэх;
 - 10.1.7. худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;
 - 10.1.8. хууль тогтоомжид заасан бусад мэдээллийг мэдээлэх.

⁷ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2005 оны 48 дугаарт нийтлэгдсэн.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

МЭДЭЭЛЭЛ АВАХ, МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ЖУРАМ

11 дүгээр зүйл.Мэдээлэл авах

- 11.1. Иргэн, хуулийн этгээд нь хүний эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал, байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад дараах мэдээллийг энэ хуулийн 3.1-д заасан байгууллагаас авах эрхтэй:
 - 11.1.1. тухайн байгууллагын эзэмшилд байгаа бүх төрлийн мэдээ, баримт бичиг, гэрээ, контракттай холбоотой мэдээлэл;
 - 11.1.2. тухайн байгууллагын эзэмшилд байгаа эд зүйлтэй холбоотой мэдээлэл;
 - 11.1.3. тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээлэл.
- 11.2. Мэдээлэл авах тухай иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авч байгаа энэ хуулийн 3.1-д заасан байгууллагын холбогдох албан тушаалтан иргэнд энэ хуульд зааснаас бусад шаардлага тавихыг хориглоно.
- 11.3. Мэдээлэл авах тухай иргэн, хуулийн этгээдийн хүсэлт дараах шаардлагыг хангасан байна:
 - 11.3.1. хүсэлт гаргагч нь иргэн бол эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын буюу цахим шуудангийн хаяг, утасны дугаар, иргэний үнэмлэх, эсхүл түүнтэй адилтгах бичиг баримтын дугаарыг бичиж, гарын үсгээ зурсан байх;
 - 11.3.2. хүсэлт гаргагч нь хуулийн этгээд бол нэр, хаяг буюу цахим шуудангийн хаяг, улсын бүртгэлийн дугаараа бичиж, хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсгээ зурсан байх.
- 11.4. Иргэн энэ хуулийн 11.3.1-д заасны дагуу хүндэтгэн үзэх шалтгаанаар гарын үсгээ зурж чадахгүй бол бусдаар төлөөлүүлэн зуруулж болох бөгөөд хүсэлтийг иргэд бичгээр хамтран гаргасан бол түүнд бүгд гарын үсэг зурах, эсхүл тэдгээрийн төлөөлөгч гарын үсэг зурж, төлөөлөх эрхээ нотлох баримт бичгийг хавсаргана.

12 дугаар зүйл.Мэдээлэл хүсэгчийн эрх, үүрэг

- 12.1. Мэдээлэл хүсэгч мэдээлэл авах талаар дараах эрх эдэлнэ:
 - 12.1.1. эрх тэгш байх;
 - 12.1.2. мэдээлэл авах хэлбэрээ сонгох;
 - 12.1.3. мэдээлэл авах болсон шаардлага, үндэслэлээ тайлбарлахгүй байх;
 - 12.1.4. мэдээлэлтэй холбогдсон асуудлаар нэмэлт лавлагаа авах;
 - 12.1.5. мэдээллийн агуулгын талаар амаар тайлбарлуулах;
 - 12.1.6. мэдээллийн албан ёсны эх сурвалжийг мэдэх;
 - 12.1.7. мэдээлэл авах эрхийг нь зөрчсөн гэж үзвэл эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах;

- 12.1.8. хуульд заасан бусад эрх.
- 12.2. Мэдээлэл хүсэгч мэдээлэл авахдаа дараах үүрэг хүлээнэ:
- 12.2.1. хуульд заасан мэдээлэл авах журмыг биелүүлэх;
 - 12.2.2. мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх;
 - 12.2.3. авах мэдээллээ бодитой тодорхойлсон байх.

13 дугаар зүйл. Хүсэлтийг хянан үзэх

- 13.1. Мэдээлэл авах тухай иргэн, хуулийн этгээдийн хүсэлт /цаашид “хүсэлт” гэх-/ийг хүлээн авсан албан тушаалтан дараах байдлаар хянан үзнэ:
- 13.1.1. хүсэлт нь энэ хуулийн 11.3-т заасан шаардлагыг хангасан эсэх;
 - 13.1.2. иргэний үнэмлэхийн, эсхүл түүнтэй адилтгах бичиг баримтын дугаараар нь тухайн иргэн, хуулийн этгээдтэй холбогдох мэдээлэл үнэн зөв эсэхийг шалгах;
 - 13.1.3. хүсэлтэд дурдсан мэдээлэл тухайн байгууллагын эзэмшилд байгаа эсэх, байхгүй тохиолдолд тухайн хүсэлтийг холбогдох байгууллагад нь 2 хоногийн дотор шилжүүлж, энэ тухай иргэн, хуулийн этгээдэд мэдэгдэх;
 - 13.1.4. энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан үндэслэл байгаа эсэх.

- 13.2. Хүсэлтийг энэ хуулийн 18 дугаар зүйлд зааснаас гадна дараах үндэслэлээр буцаана:

- 13.2.1. хүсэлт нь энэ хуулийн 11.3-т заасан шаардлагыг хангаагүй;
- 13.2.2. хүсэлтэд дурдсан мэдээлэл тухайн байгууллагын эзэмшилд байхгүй бөгөөд хүсэлтийг холбогдох байгууллагад шилжүүлэх боломжгүй.

- 13.3. Хүсэлтийг буцаахдаа шалтгаан, үндэслэлийг тодорхой заана.

14 дүгээр зүйл. Мэдээлэл өгөх

- 14.1. Энэ хуулийн 3.1-д заасан байгууллага нь тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглоогүй мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд өгөх үүрэгтэй.
- 14.2. Энэ хуулийн 3.1-д заасан байгууллага нь иргэнийг хүлээн авч уулзах байр, хүсэлтийг хүлээн авах цагийн хуваарийг тогтоож нийтэд мэдээлнэ.
- 14.3. Энэ хуулийн 3.1-д заасан байгууллага өөрт хадгалагдаж байгаа мэдээллийг хууль бусаар устгах, иргэдээс мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэхэд нь саад учруулахыг хориглоно.
- 14.4. Энэ хуулийн 3.1.10-т заасан байгууллага нь дор дурдсан мэдээллийг нийтэд заавал нээлттэй байлгана:
- 14.4.1. тухайн байгууллагын явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн амын эрүүл

мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийг илтгэн харуулах мэдээлэл;

- 14.4.2. тухайн байгууллагын мэдэлд байгаа бөгөөд хадгалалт, хамгаалалтын горим нь зөрчигдсөн тохиолдолд хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болзошгүй бүх төрлийн хорт, цацраг идэвхт бодисын хор хөнөөлийг тодорхойлсон мэдээлэл;
- 14.4.3.нийтэд мэдээлэхээр хуульд заасан бусад мэдээлэл.
- 14.5. Энэ хуулийн 3.1.10-т заасан байгууллага өөрийн байгууллагын нууцын жагсаалтыг батлан нийтэд мэдээлэх үүрэгтэй.
- 14.6. Мэдээллийг амаар, бичгээр, цахим хэлбэрээр өгч болох бөгөөд иргэн, хуулийн этгээд нь мэдээлэлтэй биечлэн танилцаж болно.
- 14.7. Хариуг нь шууд өгөх боломжтой хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж хариуг өгнө.
- 14.8. Хуульд өөрөөр заагаагүй бол мэдээллийг хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд ажлын 7 өдрийн дотор өгөх бөгөөд хүсэлтийг иргэд хамтран гаргасан бол тэдгээрийн төлөөлөл болох нэг иргэнд мэдээллийг өгнө.
- 14.9. Шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 14.8-д заасан хугацааг нэг удаа 7 хоногоор сунгаж болно.
- 14.10.Хүсэлтийн хариуг өгсөн он, сар, өдөр, хариу бэлтгэсэн албан тушаалтны нэр, мэдээлэл олгосон хэлбэр зэргийг бүртгэлд тэмдэглэн хадгална.

15 дугаар зүйл.Цахим хэлбэрээр мэдээлэл авах, өгөх

- 15.1. Иргэн, хуулийн этгээд цахим хэлбэрээр мэдээлэл авах хүсэлт гаргаж болно.
- 15.2. Цахим хэлбэрээр мэдээлэл авах хүсэлт гаргасан тохиолдолд иргэн, хуулийн этгээд нь цахим баримт бичиг үйлдэн, тоон гарын үсэг зурах бөгөөд түүнд өөрийн иргэний үнэмлэх, эсхүл түүнтэй адилтгах бичиг баримтын дугаарыг бичиж, холбогдох байгууллагад цахим шуудангаар ирүүлсэн байна.
- 15.3. Мэдээллийг цахим хэлбэрээр иргэн, хуулийн этгээдэд өгөх тохиолдолд тухайн байгууллагыг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурах бөгөөд хүсэлт гаргагчид мэдээллийг цахим шуудангаар хүргүүлнэ.
- 15.4. Цахим хэлбэрээр мэдээлэл өгөхөд энэ хуулийн 11-14 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

16 дугаар зүйл.Үйлчилгээний хөлс

- 16.1. Иргэн, хуулийн этгээд мэдээлэл авах тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.
- 16.2. Энэ хуулийн 16.1-д заасан үйлчилгээний хөлсний хэмжээг тухайн мэдээллийг өгөх зардалтай нийцүүлэн тухайн байгууллагын удирдлага тогтоох бөгөөд үйлчилгээний хөлс тооцох аргачлал, үйлчилгээний хөлс

төлөх, түүнээс хөнгөлөх, чөлөөлөх журмыг Засгийн газар батална.

16.3. Энэ хуулийн 16.1-д заасан үйлчилгээний хөлсийг хууль тогтоомжид заасан бусад үйлчилгээний хөлстэй давхардуулан авахгүй.

16.4. Үйлчилгээний хөлс нь уг мэдээллийг өгөхтэй холбогдон гарах хувилах, шуудангаар хүргүүлэх зэрэг шууд зардлаас хэтэрч болохгүй.

17 дугаар зүйл.Гомдол гаргах, гомдлыг хянан шийдвэрлэх

17.1. Иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл авах эрхийг зөрчсөн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдлийн талаар дээд шатны байгууллага, албан тушаалтан, Хүний эрхийн Үндэсний Комисс, эсхүл шүүхэд гомдол гаргаж болно.

17.2. Энэ хуулийн 17.1-д заасан гомдлыг хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг дараах хуулиар зохицуулна:

17.2.1. гомдлыг дээд шатны байгууллага, албан тушаалтанд гаргаж байгаа бол Иргэээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль⁸, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль⁹;

17.2.2. гомдлыг Хүний эрхийн Үндэсний Комисст гаргаж байгаа бол Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль¹⁰;

17.2.3. гомдлыг шүүхэд гаргаж байгаа бол Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль.

⁸ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2003 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

⁹ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

¹⁰ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль-“ Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2000 оны 48 дугаарт нийтлэгдсэн.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ЗАРИМ ТӨРЛИЙН МЭДЭЭЛЛИЙГ ИРГЭН, ХУУЛИЙН
ЭТГЭЭДЭД ӨГӨХИЙГ ХОРИГЛОХ

18 дугаар зүйл.Онцгой нөхцөл

18.1. Дараах тохиолдолд мэдээллийг бусдад задруулахыг хориглоно:

- 18.1.1. тухайн мэдээллийг нийтэд ил болгосноор Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, нийтийн эрх ашигт хохирол учруулах бодитой үндэслэл байгаа бол;
- 18.1.2. тухайн мэдээлэл нь Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, өрсөлдөөний болон мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хянан шалгагдаж байгаа асуудалтай холбоотой бол;
- 18.1.3. хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны явцад төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах шаардлагатай бол;
- 18.1.4. тухайн мэдээлэл нь олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах явцтай холбоотой бол;
- 18.1.5. хууль тогтоомжид заасан бусад.

19 дүгээр зүйл.Оюуны өмчийг хамгаалах

19.1. Оюуны өмчтэй холбоотой мэдээллийг өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахыг хориглоно.

20 дугаар зүйл.Хувь хүний нууцыг хамгаалах

20.1. Хуульд өөрөөр заагаагүй бол хувь хүн бичгээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд түүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, мэргэжил, боловсрол, албан тушаал, ажлын газрын хаяг, ажлын утаснаас бусад мэдээллийг бусдад задруулахыг хориглоно.

21 дүгээр зүйл.Байгууллагын нууцыг хамгаалах

21.1. Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой, эсхүл шударга өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор нууцалж хамгаалалтдаа авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болох нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжтэй холбоотой мэдээллийг тухайн аж ахуйн нэгжийн эрх бүхий этгээдийн /гүйцэтгэх удирдлага буюу түүнээс эрх олгосон бусад этгээд/ бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахыг хориглоно.

ТАВДУГААР БҮЛЭГ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ

22 дугаар зүйл. Мэдээлэл, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

22.1. Мэдээлэл, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийг хангахтай холбоотой асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

22.1.1. энэ хуулийн 7 дугаар зүйл, 8.1 дэх хэсэг, 9, 10 дугаар зүйлд заасан мэдээллийг цахим хэлбэрт оруулж, мэдээллийн санг үүсгэх, түгээх, ашиглах, түүний байнгын тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах нийтлэг журмыг боловсруулах;

22.1.2. мэдээллийг цахим хэлбэрт оруулж, мэдээллийн сан үүсгэх, түгээх, ашиглах, түүний байнгын тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангах чиглэлээр төрийн байгууллагуудын дунд сургалт зохион байгуулах, тэдгээрт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

22.1.3. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

22.2. Энэ хуулийн 22.1.1-д заасан журмыг Засгийн газар батална.

23 дугаар зүйл. Тэмдэглэл хөтлөх

23.1. Энэ хуулийн 3.1-д заасан байгууллага нь мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах боломжийг хангах зорилгоор тэмдэглэл хөтлөх бөгөөд тэмдэглэлд дараах зүйлийг тусгана:

23.1.1. мэдээлэл авах хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийн нэр, хаяг;

23.1.2. мэдээлэл авах хүсэлт хүлээн авсан, хянасан буюу буцаасан, мэдээллийг өгсөн хугацаа;

23.1.3. бусад.

24 дүгээр зүйл. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт

24.1. Энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтан мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг хуульд заасан эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ.

24.2. Төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежертэй байгуулах үр дүнгийн гэрээнд мэдээллийн ил тод байдлыг хангах талаар тусгаж, үнэлгээний гол шалгуурын нэг болгон дүгнэнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

БУСАД

25 дугаар зүйл. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

- 25.1. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомж зөрчсөн албан хаагчийг зөрчлийн шинж байдлыг харгалзан түүнийг томилсон эрх бүхий этгээд Төрийн албаны тухай хуулийн¹¹ 26 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулна.
- 25.2. Иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл авах эрхийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн албан хаагчийг эрх бүхий этгээд Төрийн албаны тухай хуулийн 25.1.1-д заасан үндэслэлээр төрийн албанаас хална.
- 25.3. Энэ хуулийн 25.2-т заасныг зөрчсөн шийдвэр гаргах эрх бүхий этгээдийг шүүгч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ

11 Төрийн албаны тухай хууль- Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 06 сарын 16 өдөр

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7, 8 дугаар зүйл, 9.1.5 дахь заалт, 9.3 дахь хэсэг, 10 дугаар зүйлийг 2011 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл.

Энэ хуулийг Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 2 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 54

Улаанбаатар
хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 16.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл өгөх үйлчилгээний хөлс төлөх, түүнээс хөнгөлөх, чөлөөлөх журмыг хавсралт ёсоор баталсугай.
2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэгт үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд
Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

Н.АЛТАНХУЯГ
Ч.САЙХАНБИЛЭГ

МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС ТӨЛӨХ, ТҮҮНЭЭС ХӨНГӨЛӨХ, ЧӨЛӨӨЛӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл өгөх үйлчилгээний хөлс төлөх, түүнээс хөнгөлөх, чөлөөлөхтэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл өгөх үйл ажиллагаанд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, энэхүү журмыг дагаж мөрднө.
- 1.3. Энэхүү журмын 1.1-д заасан үйлчилгээний хөлсийг хууль тогтоомжид заасан бусад үйлчилгээний хөлстэй давхардуулан авахгүй.

Хоёр. Үйлчилгээний хөлс төлөх

- 2.1. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 3.1-д заасан байгууллага нь иргэн, хуулийн этгээдэд амаар болон цахим хэлбэрээр өгөх мэдээллийг үнэ төлбөргүй өгнө.
- 2.2. Иргэн, хуулийн этгээд нь цаасан хэлбэрээр мэдээлэл авах тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.
- 2.3. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 3.1-д заасан байгууллага нь энэ журмын 2.2-т заасан үйлчилгээний хөлсний жишиг хэмжээг дараах байдлаар тооцно:
 - 2.3.1. А-4 (нэг тал) нэг хуудас мэдээлэл хэвлэх-50 төгрөг
 - 2.3.2. А-4 (нэг тал) нэг хуудас мэдээлэл хувилах-25 төгрөг
- 2.4. Тухайн байгууллага нь энэ журмын 2.3-т заасан үйлчилгээний хөлсний хэмжээг зах зээлийн үнийн өөрчлөлтэй уялдуулан өөрчлөн тогтоож болно. Үйлчилгээний хөлс нь уг мэдээллийг өгөхтэй холбогдон гарах хэвлэх, хувилах, шуудангаар хүргүүлэх зэрэг шууд зардлаас хэтэрч болохгүй.
- 2.5. Иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл өгөхдөө энэ журмын 2.3, 2.4-т зааснаас өөр хэлбэрээр үйлчилгээний хөлс авахыг хориглоно.
- 2.6. Энэ журмын 2.2-т заасан үйлчилгээний хөлсийг тухайн байгууллагад бэлэн болон бэлэн бусаар төлнө. Үйлчилгээний хөлс төлөхтэй холбогдсон нарийвчилсан журмыг энэхүү журамд нийцүүлэн тухайн байгууллага тогтоож болно.
- 2.7. Мэдээллийг шуудангаар хүргүүлэх тохиолдолд энэ журмын 2.3, 2.4-т заасан үйлчилгээний хөлс дээр шуудангийн зардлыг нэмж тооцно. Шуудангийн үнийг тооцоходоо “Монгол шуудан” компанийн тарифыг баримтална.

Гурав. Үйлчилгээний хөлсөөс хөнгөлөх, чөлөөлөх тухай

- 3.1. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн энэхүү журмын 2.3, 2.4-т заасан үйлчилгээний хөлсийг төлөхгүй.

Дөрөв. Бусад

- 4.1. Байгууллагын цахим хуудсанд байрлуулсан мэдээллийг тухайн байгууллага хэвлэж, олшруулж өгөхгүй.
- 4.2. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 3.1-д заасан байгууллага нь иргэн, хуулийн этгээдэд мэдээллийг цахим хэлбэрээр өгөх нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

Тав. Хариуцлага

- 5.1. Энэ журмыг зөрчсөн эрх бүхий албан тушаалтанд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-----oOo-----